



## ГАРЧИГ

ᠭᠠᠷᠴᠢᠭ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

103.	Нотариатын тухай	388
104.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	415
105.	Арбитрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	416
106.	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	416
107.	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	417
108.	Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	417
109.	Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	418
110.	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	419
111.	Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	419
112.	Иргэний бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	420
113.	Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	420
114.	Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	421
115.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	421



116.	Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	422
117.	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	422
118.	Тээвэрч дилбэрэх бодис, тээмэгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	423
119.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	424
120.	Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	424
121.	Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	425
122.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	426
123.	Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	426
124.	Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	427
125.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	428
126.	Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	428
127.	Хувиргасан амьд организмн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	429
128.	Нотариатын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай	429
129.	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай	430
130.	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зарим	

	хэргийг хүчингүй болсонд тооцох тухай	446
131.	Төв банк /Монголбанкны/-ны тухай хуульд нэмэлт оруулах тухай	447
132.	Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай	447
133.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	448
134.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажла, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай	448
135.	Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	449
136.	Гадаадын тээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай	449

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

137.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 13	450
138.	Зээлийн баталгааны дээд хэмжээг тогтоох тухай	Дугаар 14	450
139.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 15	451

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

140.	Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай	Дугаар 317	452
------	---	------------	-----



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НОТАРИАТЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь нотариатын үйл ажиллагааны зарчим, нотариатчийн эрх зүйн байдлыг тогтоож, нотариатын үйлдэл хийх замаар иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Нотариатын тухай хууль тогтоомж

2.1.Нотариатын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Иргэний хууль<sup>2</sup>, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Нотариат аар гэрчлүүлэхтэй холбогдсон харилцааг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд төрийн байгууллага, албан тушаалтан баримт бичгийг нотариатчаар гэрчлүүлэх шийдвэр гаргаж болохгүй.

#### 3 дугаар зүйл.Нотариатын зарчим

3.1.Нотариатч дараахь зарчмыг баримтална:

3.1.1.хууль дээдлэх;

3.1.2.хараат бус, бие даасан байх;

3.1.3.тэгш эрхийг хангах;

3.1.4.шударга ёсыг сахих;

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Иргэний хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

3.1.5.үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах;

3.1.6.ёс зүйн дүрмийг чанд баримтлан ажиллах.

#### **4 дүгээр зүйл.Нотариатч, түүний чиг үүрэг**

4.1.Нотариатчийн үйл ажиллагааг нотариатч болон энэ хуулийн 16.2, 16.3-т заасан нотариатчийн үүрэг гүйцэтгэгч эрхлэн явуулна.

4.2.Нотариатчийн чиг үүргийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэн гүйцэтгэж, нотариатын үйлчилгээний хөлс, орлогоор санхүүжин ажиллаж байгаа иргэнийг нотариатч гэнэ.

4.3.Нотариатч нь төрийн нэрийн өмнөөс хөндлөнгийн гэрчийн үүрэг гүйцэтгэж, эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус харилцаанд оролцож байгаа этгээдэд эрх зүйн зөвлөгөө өгөх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.4.Нотариатч дор дурдсан тодорхой чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.4.1.нотариатчаар гэрчлүүлснээр хүчин төгөлдөр, үл маргах шянтэй болох үйлдэл, баримт бичгийг гэрчлэх;

4.4.2.үйлчлүүлэгч хүсвэл нотариатчаар гэрчлүүлэхээр хуульд зааснаас бусад үйлдэл, баримт бичгийг үл маргах шянтэй болгох зорилгоор гэрчлэх;

4.4.3.гарын үсгийн үнэн зөвийг гэрчлэх;

4.4.4.хууль зүйн агуулга бүхий үйлдэл, баримт бичгийг хуульд заасан тохиолдолд болон шүүх, төрийн бусад байгууллагын хүсэлтээр гэрчлэх;

4.4.5.хуульд заасан бусад.

4.5.Нотариатч гэрчилсэн үйлдэл, баримт бичигт холбогдох нотлох баримтыг хадгалах бөгөөд тэдгээрийн хуулбарыг болон хуульд заасны дагуу баримт бичгийн эхийг шаардлагатай этгээдэд олгоно.

#### **5 дугаар зүйл.Нотариатчийн ажлын байр**

5.1.Нотариатч тогтоосон тойрогтоо үйл ажиллагаа эрхлэн явуулах ажлын байртай байх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол нотариатч нотариатын үйлдлийг зөвхөн ажлын байрандаа хийнэ.

5.2.Эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар үйлчлүүлэгч нотариатчийн ажлын байранд ирэх боломжгүй бол нотариатч түүний хүсэлтээр байгаа газарт нь очиж нотариатын үйлдэл хийж болно.

#### **6 дугаар зүйл.Нотариатчид тавих шаардлага**

6.1.Дараахь шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн нотариатын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй:

6.1.1.мэргэшлийн шалгалтад тэнцсэн;

6.1.2.ял шийтгэлгүй;

6.1.3.нотариатын үйлдэл хийх ажлын байртай.

6.2.Нотариатч багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэхээс өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгэхийг хориглоно.

6.3.Нотариатч өөрийн орны болон олон улсын нотариатын байгууллагын сонгуульд ажил, албан тушаал эрхэлж болно.

#### **7 дугаар зүйл.Нотариатын тойрог**

7.1.Нотариатч тогтоосон тойрогт үйл ажиллагаагаа явуулах бөгөөд тойрог сольж ажиллахыг хориглоно.

7.2.Нотариатын тойрог, түүнд ажиллах нотариатчийн тоог энэ хуулийн 8.1-д заасан Монголын Нотариатчдын Танхимын саналыг харгалзан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

7.3.Үл хөдлөх эд хөрөнгийг бусдад шилжүүлэхтэй холбогдсон аливаа хэлцэл болон өвлөх эрхтэй холбогдсон баримт бичгийг зөвхөн тухайн эд хөрөнгө байгаа тойргийн нотариатч гэрчилнэ.

7.4.Нотариатч тойрог шилжих тохиолдолд мэргэшлийн шалгалт дахин өгөх бөгөөд уг шалгалтад тэнцсэн нотариатч тухайн тойрогт сул орон тоо гартал дараалал хүлээнэ.

#### **8 дугаар зүйл.Нотариатын байгууллагын бүтэц, зохион байгуулалт**

8.1.Нотариатчдыг энгээндээ нэгтгэсэн, тэдний мэргэжлийн үйл ажиллагааг энэ хууль, болон, өөрийн дүрэмд заасны дагуу уялдуулан зохицуулах, эрх ашгийг нь хамгаалах зорилготой Монголын Нотариатчдын

танхим /цаашид "Танхим" гэх/ ажиллана.

8.2.Нотариатын байгууллага нь Танхимын бүх гишүүдийн хурал, Танхим, түүний Удирдах зөвлөл, танхимын аймгийн болон нийслэл дэх дүүргийн тойргийн салбараас бүрдэх бөгөөд тэдгээрийн эрх хэмжээг Танхимын дүрмээр тогтооно.

8.3.Танхимын ерөнхийлөгч Танхимын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах бөгөөд түүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. Танхимын ерөнхийлөгчийг нэг удаа улируулан сонгож болох бөгөөд түүний эрх хэмжээг Танхимын дүрмээр тогтооно.

8.4.Танхимын дэргэд Сахилгын болон Хяналтын зөвлөл ажиллах бөгөөд тэдгээрийн эрх хэмжээг Танхимын дүрмээр тогтооно.

8.5.Танхимын бүх гишүүдийн хурал Танхимын дүрмийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

8.6.Танхим нь нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд нотариатын үйл ажиллагаатай холбогдсон бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлж ажиллах бөгөөд хуульд заасан төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээ, мэдээлэл, тайлан, тоо баримтыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай үнэ төлбөргүй солилцож, харилцан мэдээлнэ.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **НОТАРИАТЫН ҮЙЛДЭЛ ХИЙХ ХЭЛ, ТАМГА, БАТАЛГААНЫ ТЭМДЭГ, БАРИМТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС, ЗАРДАЛ**

#### **9 дүгээр зүйл.Нотариатын үйлдэл хийх хэл**

9.1.Нотариатын үйлдэл хийх, баримт бичиг, нотариатын үйлдэл хийсэн тухай тэмдэглэл үйлдэх албан ёсны хэл нь монгол хэл байна.

9.2.Хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар нь нотариатын үйлдэл, баримт бичгийг монгол хэлээр үйлдэх бөгөөд үйлчлүүлэгчийн хүсэлтээр холбогдох баримт бичгийг орчуулан өгч болно.

#### **10 дугаар зүйл.Нотариатчийн тамга, баталгааны тэмдэг**

10.1.Нотариатч тогтоосон загварын дагуу үйлдсэн тамга, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.



10.2.Нотариатч ажиллаагүй сумын Засаг даргын Тамгын газрын дарга нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэхдээ тухайн сумын Засаг даргын Тамгын газрын тамга, тэмдгийг хэрэглэнэ.

10.3.Хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын эрх бүхий албан тушаалтан нь нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэхдээ тухайн дипломат төлөөлөгчийн газрын тамга, тэмдгийг хэрэглэнэ.

## **11 дүгээр зүйл.Нотариатын баримт**

11.1.Нотариатч болон энэ хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хийсэн нотариатын үйлдсэн буюу гэрчилсэн бусад баримт бичиг, түүний хуулбар, лавлагааг нотариатын баримт гэнэ.

11.2.Энэ хуульд заасны дагуу үйлдэж олгосон нотариатын баримт нотлох баримтын эх сурвалж болох бөгөөд хуульд заасан тохиолдолд нотариатын баримтыг гүйцэтгэх баримт бичигт тооцно.

## **12 дугаар зүйл.Нотариатын үйлчилгээний хөлс, зардал**

12.1.Нотариатын үйлчилгээ төлбөртэй байна.

12.2.Нотариатч хуульд заасан нотариатын үйлдэл хийх, хууль зүйн зөвлөгөө өгөх, баримт бичиг боловсруулах, нотариатын үйлдлийн талаар лавлагаа гаргахад үйлчилгээний хөлс авах бөгөөд үйлчлүүлэгчийн хүсэлтээр ажлын байрнаасаа өөр газар очиж үйлчилсэн бол үйлчилгээний хөлс болон тээврийн зардлыг үйлчлүүлэгчээс авна.

12.3.Танхимын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 12.2-т заасан нотариатын үйлчилгээний хөлс болон тээврийн зардлын хэмжээг батална.

12.4.Энэ хуулийн 16.2, 16.3-т заасан албан тушаалтан нотариатын үйлчилгээний хөлсийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд<sup>1</sup> заасны дагуу авна.

12.5.Нотариатч энэ хуульд зааснаас бусад үйлчилгээний хөлс, зардал болон шагнал, урамшуулал авахыг хориглоно.

12.6.Нотариатч үйлчлүүлэгчийн хүсэлтээр нотариатын үйлчилгээг цуцлах тохиолдолд үйлчилгээний хөлс болон тээврийн зардлыг буцаан олгохгүй.

<sup>1</sup> Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль - Төрийн мэдээлэл эхлэлтэгийн 2011 оны 1 дугаарт нийтлэгдсэн.





12.7.Нотариатч энэ хуулийн 12.3-т заасан үйлчилгээний хөлс болон тээврийн зардлын хэмжээг баталсан шийдвэрийг үйлчлүүлэгчид харагдахуйц газар байрлуулна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХ**

### **13 дугаар зүйл.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

13.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нотариатын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1.нотариатчийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, журам, заавар, аргачлал батлах;

13.1.2.нотариатын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

13.1.3.нотариатчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих;

13.1.4.нотариатчийн мэргэшлийн шалгалтыг зохион байгуулах;

13.1.5.нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

13.1.6.нотариатчдын нэгдсэн бүртгэл хөтлөх;

13.1.7.нотариатчийг бэлтгэх, сургах, давтан сургах ажлыг зохион байгуулах;

13.1.8.нотариатчдын үйл ажиллагаанд судалгаа, дүгнэлт хийх;

13.1.9.хуульд заасан бусад.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг Танхимаар гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлж болно.



**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ  
МЭРГЭШЛИЙН ШАЛГАЛТ, НОТАРИАТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

**14 дүгээр зүйл. Мэргэшлийн шалгалт**

14.1. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулсан мэргэшлийн шалгалтад тэнцсэн тохиолдолд олгоно.

14.2. Мэргэшлийн шалгалтад хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэн оролцоно.

**15 дугаар зүйл. Мэргэшлийн хороо**

15.1. Нотариатчийн мэргэшил, ур чадварын түвшинд дүгнэлт гаргах, мэргэшлийн шалгалт явуулах чиг үүрэг бүхий Мэргэшлийн хороо хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.

15.2. Мэргэшлийн хороо долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд даргыг нь гишүүдийн олонхийн саналаар тэдгээрийн дотроос сонгоно.

15.3. Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд шүүх, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Танхимаас тус бүр хоёр, эрдмийн зэрэг цолтой хуульч нэг хүний төлөөлөл байна.

15.4. Мэргэшлийн хорооны гишүүн хууль зүйн ухааны магистр болон түүнээс дээш эрдмийн зэрэг, цолтой байна.

15.5. Мэргэшлийн хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

15.6. Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.7. Мэргэшлийн шалгалтыг нотариатын тойрог, нотариатчийн орон тоо, хэрэгцээг харгалзан улсын хэмжээнд гурван жил тутам явуулах бөгөөд нотариатч ажиллаагүй тухайн тойрогт мэргэшлийн шалгалт явуулах эсэхийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухай бүр шийдвэрлэнэ.

15.8. Мэргэшлийн шалгалт эхлэхээс 45-аас доошгүй хоногийн өмнө



энэ тухай өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

### **16 дугаар зүйл. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох**

16.1.Энэ хуулийн 6.1-д заасан шаардлагыг хангасан иргэнд Мэргэшлийн хорооны саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно.

16.2.Нотариатч ажиллаагүй суманд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх авсан сумын Засаг даргын Тамгын газрын дарга нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэнэ.

16.3.Хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх авсан албан тушаалтан нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэнэ.

16.4.Энэ хуулийн 16.2, 16.3-т заасан нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэж байгаа албан тушаалтанд энэ хуульд заасан нотариатчийн эрх, үүрэг, холбогдох бусад зүйл, заалт нэгэн адил хамаарна.

### **17 дугаар зүйл.Нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх**

17.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь үндэслэлээр түдгэлзүүлж болно:

17.1.1.энэ хуульд заасан нотариатын үйлдэл хийх журмыг зөрчсөн нь тогтоогдсон бол 3 сар хүртэл хугацаагаар;

17.1.2.нотариатч эрүүгийн хариуцлагад татагдсан тохиолдолд эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн эцсийн шийдвэр гартал;

17.1.3.энэ хуулийн 21.2, 21.3, 22.1, 24.1-д заасныг зөрчсөн бол 6 сар хүртэл хугацаагаар;

17.1.4.нотариатч төрийн албан тушаалд томилогдсон, сонгогдсон тохиолдолд тухайн шийдвэрийг нь үндэслэн.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан түдгэлзүүлэх үндэслэл арилсан тохиолдолд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээж,

**18 дугаар зүйл. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох**

18.1. Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь үндэслэлээр нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

18.1.1. нотариатч эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон бол өөрийнх нь хүсэлт, эсхүл эмнэлгийн дүгнэлт, холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн;

18.1.2. нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсан нь тогтоогдсон;

18.1.3. нотариатч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

18.1.4. нотариатч эрх зүйн чадамжгүй болсон;

18.1.5. нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

18.1.6. нотариатчийн ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн.

18.2. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд нотариатч тамга, баталгааны тэмдэг, баримт бичгээ Тэнхимд хүлээлгэн өгнө.

18.3. Энэ хуулийн 18.2-т заасныг зөрчсөн бол тамга, баталгааны тэмдэг, баримт бичиг хүчингүй болсныг нийтэд мэдээлнэ.

**19 дүгээр зүйл. Нотариатчийн үйл ажиллагаа дуусгавар болох**

19.1. Дараахь тохиолдолд нотариатчийн үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцно:

19.1.1. нас барсан;

19.1.2. Монгол Улсын харьяатаас гарсан.

19.2. Нотариатч Монгол Улсын харьяатаас гарсан тухайгаа хууль

зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд мэдэгдэнэ.

## **ТАВДУГААР БҮЛЭГ НОТАРИАТЧИЙН ТАНГАРАГ, ЭРХ, ҮҮРЭГ, БАТАЛГАА**

### **20 дугаар зүйл. Нотариатчийн тангараг**

20.1. Нотариатч анх үйл ажиллагаагаа эхлэхийн өмнө тангараг өргөх бөгөөд тангараг өргөх ёслолын журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **21 дүгээр зүйл. Нотариатчийн эрх, үүрэг**

21.1. Нотариатч дараахь эрх эдэлнэ:

21.1.1. нотариатын үйлдэл хийлгэж байгаа этгээд /цаашид "үйлчлүүлэгч" гэх/-ийн хувийн байдлыг тогтоох;

21.1.2. нотариатын үйлдэл хийхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, түүний хуулбар, шаардлагатай мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардан авах;

21.1.3. шаардлагатай гэж үзвэл холбогдох этгээдийг дуудан ирүүлэх;

21.1.4. хуульд заасан бусад.

21.2. Нотариатч дараахь үүрэг хүлээнэ:

21.2.1. үйлчлүүлэгчид эрх, үүргийг нь тайлбарлан, тухайн үйлдлийг өөрийн хүсэл зоригийн дагуу хэрэгжүүлж байгаа эсэхийг тодруулан, эрх зүйн үр дагавар, хууль зүйн ач холбогдлыг тайлбарлаж зөвлөгөө өгөх;

21.2.2. нотариатчийн ёс зүйн дүрмийг чанд сахиж, мэргэжлийн нууцыг хадгалах;

21.2.3. гишүүний татвараа төлөх;

21.2.4. хариуцлагын даатгалд даатгуулах;

21.2.5. нотариатын үйлдэлд холбогдох баримт бичгийн үнэн, зөв эсэхийг хянаж нягтлах;

21.2.6. нотариатын үйлдэлд холбогдох баримт бичиг,



түүний хуулбар, шаардлагатай мэдээллийг хуулийн байгууллагын шаардсаны дагуу гаргаж өгөх;

21.2.7.нотариатын үйлдэл хийх эрхээ гагцхүү өөрөө хэрэгжүүлж, тамга, баталгааны тэмдгийг бусдад шилжүүлэхгүй байх;

21.2.8.гэрчлүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн жөвхэнэ эх мөн эсэх нь эргэлзээтэй байвал уг баримт бичгийг олгосон байгууллагаас лавлагаа болон хуулбарыг авах, тодорхойлолт гаргуулах, зайлшгүй шаардлагатай гэж үзвэл магадлан шинжлүүлэх;

21.2.9.нотариатын үйлдэл хийх явцад үйлчлүүлэгч хууль зөрчсөн болох нь илэрвэл зохих арга хэмжээ авахуулахаар холбогдох байгууллагад мэдэгдэх;

21.2.10.хуульд заасан бусад.

21.3.Нотариатчийн үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно:

21.3.1.хуурамч баримт бичгийг гэрчлэх;

21.3.2.баримт бичгийн хуулбарыг эх хувьтай нь тулгахгүйгээр гэрчлэх;

21.3.3.нотариатын үйлдэл хийж болохгүй нөхцөл байдлыг нуун дарагдуулж нотариатын үйлдэл хийх;

21.3.4.нотариатын үйлдэл хийх явцдаа олж мэдсэн үйлчлүүлэгчийн нууцыг задруулах;

21.3.5.нотариатын үйлдэл хийх, эрх зүйн зөвлөгөө өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзах.

## **22 дугаар зүйл.Нотариатын мэргэжлийн нууц**

22.1.Нотариатч төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах асуудлаар нотариатын үйлдэл хийж байгаа бол тэдгээрийн нууцыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хамгаална.

22.2.Нотариатын үйл ажиллагаа дуусгавар болсон ч нууцыг хадгалах үүрэг хэвээр хадгалагдана.

22.3.Албан үүргээ гүйцэтгэх явцдаа нотариатын үйлдлийн нууцыг мэдсэн бусад этгээдэд энэ хуулийн 22.1, 22.2 дахь хэсэг нэгэн адил хамаарна.

### **23 дугаар зүйл. Нотариатчийн хараат бус, бие даасан байдлын баталгаа**

23.1. Нотариатын үйлдэл хийхэд дарамт шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, нотариатын үйлдэл хийхийг хууль бусаар шаардахыг хориглоно.

### **24 дүгээр зүйл. Нотариатчийн хариуцлагын даатгал**

24.1. Нотариатч нь нотариатын үйлдлийг буруу хийсэн, үйлчлүүлэгчийн хувийн байдлыг буруу тогтоосон зэрэг бусад буруутай үйлдлийн улмаас үйлчлүүлэгчид хохирол учруулсан тохиолдолд түүнийг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд заавал даатгуулна.

24.2. Нотариатч даатгалын байгууллагаа өөрөө сонгоно.

24.3. Энэ хуулийн 24.1-д заасан даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ нь нийслэлд нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуу дахин нэмэгдүүлсэнээс доошгүй, орон нутагт нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуу дахин нэмэгдүүлсэнээс доошгүй байна.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ НОТАРИАТЫН ҮЙЛДЭЛ, НОТАРИАТЫН БҮРТГЭЛ, ХУГАЦАА**

### **25 дугаар зүйл. Нотариатын үйлдлийн төрөл**

25.1. Нотариатын үйлдэл дараахь төрөлтэй байна:

25.1.1. гэрээ, хэлцэл гэрчлэх;

25.1.2. гэрээслэл гэрчлэх;

25.1.3. итгэмжлэл гэрчлэх;

25.1.4. өвлөх эрхийн гэрчилгээ олгох;

25.1.5. өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах;

25.1.6. хуулийн этгээд үүсгэн байгуулах баримт бичиг гэрчлэх;

25.1.7. эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбогдох баримт бичиг гэрчлэх;

25.1.8. гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон



дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгөөс ногдох хэсгээ өмчлөх эрх гэрчлэх;

25.1.9.баримт бичгийн хуулбарыг гэрчлэх;

25.1.10.баримт бичигт зурсан гарын үсгийн үнэн зөвийг гэрчлэх;

25.1.11.нотариатын мэдэгдэх хуудас бичих.

25.2.Заавал гэрчлүүлэх нотариатын үйлдлийг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд үүнээс бусад үйлдлийг үйлчлүүлэгчийн хүсэлтээр гэрчилнэ.

## **26 дугаар зүйл.Нотариатын бүртгэл**

26.1.Нотариатч баримт бичиг, үйл явдлыг гэрчлэхдээ нотариатын бүртгэл хөтөлж түүнд нотариатчийн хийсэн нотариатын үйлдлийг он, сар, өдрийн дарааллаар нь үнэн зөв, засваргүй, гаргацтай, тодорхой бичнэ.

26.2.Нотариатын бүртгэлийн дэвтэрт үйлчлүүлэгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхний болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хэрэв нотариатын үйлдэл хийхэд тэмдэглэл хөтөлсөн бол энэ тухай тус тус тэмдэглэнэ.

26.3.Үйлчлүүлэгч, нотариатын үйлдэл хийхэд оролцсон гэрч, бусад оролцогч нотар чатын бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зурна.

26.4.Нотариатын үйлдэл хийсэн баримт бичигт дарсан баталгааны тэмдгийн дардас дээрх дугаар нь тухайн бүртгэлийн дугаартай ижил байна.

26.5.Нотариатын бүртгэлийг уусдаггүй нэг өнгийн бэхээр хөтөлнө.

## **27 дугаар зүйл.Үйлчлүүлэгчийн хувийн байдлыг тогтоох**

27.1.Нотариатч үйлчлүүлэгчийн хувийн байдлыг тогтоохдоо түүний иргэний баримт бичиг, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийг үндэслэх бөгөөд итгэмжлэл, төлөөлөл нь зохих ёсоор бүрдсэн эрх зүйн чадамжтай эсэхийг шалгаж, шаардлагатай бол эрх бүхий байгууллагын тодорхойлолт, эсхүл тухайн хүнийг таних хоёр гэрчээр тодорхойлуулан тогтоож болно.

27.2.Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал нь илтэд муудах зэрэг зайлшгүй нөхцөл байдлын улмаас нотариатын үйлдлийг яаралтай хийхэд хүрвэл үйлчлүүлэгчийн хувийн байдлыг тусгайлан тодруулахгүйгээр нотариатын үйлдэл хийсний дараа тодруулж болно.



## **28 дугаар зүйл. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг**

### **28.1. Үйлчлүүлэгч дараахь эрх эдэлнэ:**

28.1.1. энэ хуулийн 7.3-т зааснаас бусад тохиолдолд нотариатчийг өөрөө чөлөөтэй сонгох;

28.1.2. нотариатчийн хууль бус үйлдлийн талаар Танхимд, эсхүл хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гомдол гаргах;

28.1.3. нотариатчийн буруутай үйлдлийн улмаас хохирол учирвал нөхөн төлүүлэх;

28.1.4. хуульд заасан бусад эрх.

### **28.2. Үйлчлүүлэгч дараахь үүрэг хүлээнэ:**

28.2.1. нотариатын үйлдэл хийлгэх баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж өгөх;

28.2.2. нотариатчийн шаардсан асуудлаар амаар буюу бичгээр тайлбар өгөх.

28.3. Үйлчлүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг нотариатч хариуцахгүй.

## **29 дүгээр зүйл. Нотариатын үйлдэл хийх хугацаа**

29.1. Энэ хуулийн 30, 31 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд нотариатын үйлдлийг тухай бүрт нь хийнэ.

## **30 дугаар зүйл. Нотариатын үйлдэл хийхийг хойшлуулах, түдгэлзүүлэх**

30.1. Үйлчлүүлэгч согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, эсхүл өөрийн үйлдэлд хяналт тавих чадваргүй байгаа бол энэ нөхцөл байдлыг арилах хүртэл нотариатын үйлдэл хийхийг хойшлуулна.

30.2. Иргэн, хуулийн этгээдээс баримт бичиг, түүний хуулбар, шаардлагатай мэдээллийг нэмж гаргуулах буюу тэдгээрийг шинжлүүлэх шаардлага гарсан тохиолдолд нотариатын үйлдэл хийхийг тодорхой хугацаагаар хойшлуулж болно.



30.3.Нотариатчаар гэрчлүүлж байгаа баримт бичиг буюу эрхийн талаар шүүхэд нэхэмжлэл гаргасан тухай өөр этгээдээс өргөдөл ирүүлсэн тохиолдолд уг асуудлаар нотариатын үйлдэл хийхийг 3-7 хүртэл хоногийн хугацаагаар хойшлуулах бөгөөд энэ хугацаанд нэхэмжлэл гаргасан нь тогтоогдвол шүүхийн шийдвэр гартал нотариатын үйлдэл хийхийг түдгэлзүүлнэ.

### **31 дүгээр зүйл.Нотариатын үйлдэл хийхээс татгалзах**

31.1.Нотариатч дараахь тохиолдолд нотариатын үйлдэл хийхээс татгалзана:

31.1.1.үйлчлүүлэгчийн баримт бичиг нь хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд харшилж байвал;

31.1.2.өөртэй нь болон түүний гэр бүлийн гишүүнтэй нь холбоотой асуудал байвал;

31.1.3.өөрийнх нь байнгын үйлчлүүлэгчийн хувийн нууцтай холбоотой асуудлаар бусад этгээд нотариатын үйлдэл хийлгэхийг хүсвэл;

31.1.4.үйлчлүүлэгч нь эрх зүйн чадамжгүй, эсхүл төлөөлөх эрхгүй байвал;

31.1.5.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрөө итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцовол уг хэрэгт холбогдох баримт бичгийг;

31.1.6.хуульд заасан бусад.

31.2.Нотариатч энэ хуулийн 31.1-д зааснаас бусад үндэслэлээр нотариатын үйлдэл хийхээс татгалзах эрхгүй.

31.3.Энэ хуулийн 31.1-д заасныг зөрчиж хийсэн нотариатын үйлдлийг шүүх нотариатчийн болон сонирхогч этгээдийн хүсэлтээр хүчингүйд тооцно.

### **32 дугаар зүйл.Орчуулагч /хэлмэрч/-ийг оролцуулах**

32.1.Үйлчлүүлэгч нь хэлгүй, дүлий, эсхүл монгол хэл мэдэхгүй бол нотариатын үйлдэл хийх, баримт бичиг үйлдэхдээ тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч /асран хамгаалагч, харгалзан дэмжигч/ болон орчуулагч /хэлмэрч/-ийг оролцуулна. Үйлчлүүлэгч нь орчуулагч /хэлмэрч/-ийг өөрөө сонгоно.

32.2.Орчуулагч /хэлмэрч/ нь зориуд худал орчуулах буюу хэлмэрчилвэл хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

32.3.Хоёр ба түүнээс дээш талууд нотариатын үйлдэл хийлгэж байгаа тохиолдолд нэг тал нь нөгөө талдаа орчуулагч /хэлмэрч/-ийн үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

32.4.Үйлчлүүлэгч гарын үсгээ өөрийн мэддэг хэл дээр зурж болно.

### **33 дугаар зүйл.Гэрч оролцуулах**

33.1.Үйлчлүүлэгч нь хараагүй, хэлгүй, дулий, бичиг үсэг мэддэггүй, түүнчлэн эрх зүйн чадамжгүй этгээд байвал нотариатын үйлдэл хийх, баримт бичиг үйлдэхдээ тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч /асран хамгаалагч, харгалзан дэмжигч/ болон нотариатч шаардлагатай гэж үзвэл гэрчийг оролцуулна. Энэ тохиолдолд дараахь этгээдийг гэрчээр оролцуулахыг хориглоно:

33.1.1.насанд хүрээгүй;

33.1.2.эрх зүйн чадамжгүй;

33.1.3.бичиг үсэг мэддэггүй;

33.1.4.монгол хэл мэддэггүй;

33.1.5.тухайн нотариатчийн байнгын үйлчлүүлэгч.

33.2.Үйлчлүүлэгч хүсвэл нотариатын үйлдэл хийхэд гэрч оролцуулж болно.

### **34 дүгээр зүйл.Нотариатын үйлдэл хийсэн тухай тэмдэглэл, түүний агуулга**

34.1.Энэ хуулийн 32, 33 дугаар зүйлд заасан үйлчлүүлэгч, түүнчлэн бусад оролцогч оролцож байгаа бол нотариатын үйлдэл хийхэд тэмдэглэл хөтөлнө.

34.2.Энэ хуулийн 34.1-д заасан тэмдэглэлд дараахь зүйлийг тусгана:

34.2.1.үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

34.2.2.нотариатын үйлдэл хийхэд оролцсон гэрч,



орчуулагч /хэлмэрч/ зэрэг бусад оролцогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, мэргэжил, оршин суугаа газрын хаяг, тэдгээрийн тайлбар, түүнчлэн гэрч, орчуулагч /хэлмэрч/-ийг оролцуулсан үндэслэл;

34.2.3.холбогдох баримт бичгийг танилцуулсан арга хэлбэр, үйл ажиллагааны үр дүн, дэс дараалал;

34.2.4.нотариатчийн албан тушаал, овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

34.2.5.баримт бичгийг үйлдсэн он, сар, өдөр, цаг, минут.

### **35 дугаар зүйл.Тэмдэглэл үйлдэх журам**

35.1.Тэмдэглэл нь гаргацтай, утга агуулгын хувьд ойлгомжтой, үг үсгийн засваргүй, энэ зүйлийн 35.6-д зааснаас бусад тохиолдолд оруулгагүй байна.

35.2.Нотариатч тэмдэглэл үйлдсэний дараа үйлчлүүлэгч болон бусад оролцогчид уншиж сонгоно.

35.3.Тэмдэглэлд үйлчлүүлэгч болон нотариатын үйлдэл хийхэд оролцсон гэрч, орчуулагч /хэлмэрч/ зэрэг бусад оролцогч гарын үсэг зурж, нотариатч тамга, баталгааны тэмдгээ дарж баталгаажуулна.

35.4.Гарын үсэг зурж чаддаггүй хүмүүс оролцож байгаа, эсхүл энэ хуулийн 27.2-т заасан нөхцөл байдал үүссэн бол энэ тухай тайлбар бичнэ.

35.5.Тэмдэглэл хоёр буюу түүнээс дээш хуудастай бол хуудсыг дугаарлан хуудас бүрт үйлчлүүлэгч болон бусад оролцогч гарын үсэг зурж баталгаажуулна.

35.6.Үйлчлүүлэгч хүсвэл утга агуулгыг нь өөрчлөхгүйгээр тэмдэглэлд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчлүүлэгч болон нотариатын үйлдэл хийхэд оролцсон гэрч, орчуулагч /хэлмэрч/ зэрэг бусад оролцогч гарын үсэг зурж, нотариатч тамга, баталгааны тэмдгээ дарж баталгаажуулна.

35.7.Энэ хуулийн 35.6-д заасныг зөрчиж хийсэн нэмэлт, өөрчлөлтийг хүчингүйд тооцно.

### **36 дугаар зүйл.Үрэгдүүлсэн материал нөхөн бүрдүүлэх**

36.1.Нотариатч өөрт үлдсэн материалыг үрэгдүүлсэн тохиолдолд



үйлчлүүлэгчид өгсөн хувиас хуулбар хийж авах бөгөөд хуулбар дээр энэ тухай тэмдэглэл хийж, баримт бичиг хадгалах журмын дагуу хадгална.

### **37 дугаар зүйл. Үндсэн материал шалгах**

37.1. Нотариатч нь үйлчлүүлэгч, түүний эрх залгамжлагч болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтээр баримт бичиг гэрчлэхдээ тэдгээрт холбогдох бусад үндсэн материалыг шалгаж болно.

37.2. Тухайн иргэн, хуулийн этгээдэд холбогдолгүй асуудлаар үндсэн материалыг шалгахыг хориглоно.

### **38 дугаар зүйл. Баримт бичгийн хуулбар хийх**

38.1. Үйлчлүүлэгч нь гэрчлүүлсэн баримт бичгээ үрэгдүүлбэл нотариатч үлдсэн хувиас хуулбар хийж өгнө.

### **39 дүгээр зүйл. Баримт бичгийг хадгалах**

39.1. Нотариатч нь нотариатын үйлдэл хийх үндэслэл болгосон материалыг, гэрчилсэн баримт бичгийн хамт, олгосон дугаарын дагуу үдэж хадгална.

39.2. Шаардлагатай гэж үзвэл нотариатч гэрчилж байгаа баримт бичигтэй холбоотой зүйлийг гэрэл зураг, бусад бололцоотой аргаар бэхжүүлэн авч хадгална.

39.3. Нотариатч энэ хуулийн 39.1-д заасны дагуу дугаарлан үдсэн материалыг зохих журмын дагуу архивт шилжүүлэн хадгалуулна.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ НОТАРИАТЫН ТОДОРХОЙ ҮЙЛДЭЛ ХИЙХ ЖУРАМ**

### **40 дүгээр зүйл. Гэрээслэл гэрчлэх**

40.1. Нотариатч гэрээслэлийг гэрчлэхдээ дараахь баримт бичгийг үндэслэнэ:

40.1.1. гэрээслэл үйлдэх үед гэрээслэгч нь өөрийн үйлдлийг бүрэн ойлгох оюун ухааны хувьд эрүүл гэдгийг нотолсон мэргэжлийн эмчийн магадлагаа;

40.1.2. гэрээслэж байгаа хөдлөх болон үл хөдлөх эд



хөрөнгө, эрх нь гэрээслэгчийн өмч болохыг нотолсон баримт.

40.2.Нотариатч гэрээслэлийг гэрчилж, түүнд гэрээслэгч өөрөө гарын үсэг зурна.

40.3.Гэрээслэгч өвчтэй, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар гэрээслэлд өөрөө гарын үсэг зурж чадахгүй бол түүний хүсэлтийг үндэслэн хөндлөнгийн этгээдээр гарын үсэг зуруулж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчлүүлэгчийн дээрх шалтгааныг тодорхойлсон тэмдэглэлийг гэрчийг оролцуулан үйлдэнэ.

40.4.Гэрээслэгч Иргэний хуулийн 525.1-д заасны дагуу гэрээслэлээ өөрчилсөн буюу цуцалсан бол энэ тухай мэдээллийг 30 хоногийн дотор өөрчилсөн гэрээслэл, цуцалсан баримт бичгийн хамт уг гэрээслэлийг гэрчилсэн нотариатч, эсхүл Танхимд ирүүлнэ.

40.5.Нотариатч энэ хуулийн 40.4-т заасан баримт бичгийг хүлээн авмагц анхны гэрээслэл болон гэрээслэлийн бүртгэлийн дэвтэрт өөрчилсөн буюу цуцалсан тухай тэмдэглэл хийж, хувийг хавсаргана. Гэрээслэлийг анх гэрчилсэн нотариатч байхгүй тохиолдолд Танхимын ерөнхийлөгч энэ зүйлд заасан ажиллагааг гүйцэтгэнэ.

40.6.Гэрээслэл биелүүлэх тухай баримт бичгийг гэрээслэлд заавал хавсаргана.

40.7.Нотариатч гэрээслэлийн хувь тус бүрт тамга, баталгааны тэмдгээ дарж гэрчлүүлсэн он, сар, өдрийг бичиж, гарын үсэг зуран нэг хувийг гэрээслэгчид гардуулж, үлдэх хувийг Танхимд хадгалуулна.

40.8.Иргэний хуулийн 523.2-т заасан этгээд гэрээслэлийг гэрчилж болох бөгөөд энэ тохиолдолд нотариатчаар гэрчлүүлсний нэгэн адил үзнэ.

40.9.Иргэний хуулийн 523.2-т заасан этгээд гэрээслэлийг гэрчилсэн тохиолдолд өөрт үлдсэн хувийг Танхим, эсхүл энэ хуулийн 8.2-т заасан Танхимын салбарт хүлээлгэн өгөх бөгөөд уг гэрээслэлийг хүлээн авсан нотариатч гэрээслэлийг бүртгэлийн дэвтэрт бүртгэж, хүлээлгэн өгсөн этгээдээр гарын үсэг зуруулна.

#### **41 дүгээр зүйл.Итгэмжлэл гэрчлэх**

41.1.Итгэмжлэлд төлөөлүүлэгч болон төлөөлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, итгэмжлэл олгосон он, сар, өдөр, төлөөлүүлэгчээс төлөөлөгчид олгож буйгаа бүрэн эрх болон хугацааг бичнэ. Хуулийн этгээдээс итгэмжлэл олгосон тохиолдолд Иргэний хуулийн

64.2.1, 64.2.2-т заасан шаардлага хангасан эсэхийг нягталж үзнэ.

41.2.Төлөөлөгчид эрх олгосон үйл ажиллагааг бусдаар гүйцэтгүүлэх, эсхүл итгэмжлэлийг гуравдагч этгээдэд шилжүүлэх бол энэ тухай итгэмжлэлд тусгайлан заах бөгөөд ийнхүү заагаагүй бол итгэмжлэгчийн ашиг сонирхлыг хамгаалах зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд шилжүүлсэн итгэмжлэлийг гэрчлэхийг хориглоно.

41.3.Нотариатч итгэмжлэл олгохдоо Иргэний хуулийн 62.6, 64.5-д заасан хугацааг баримтлах ба хугацаатай олгох итгэмжлэлд хугацааг тоо болон үсгээр бичнэ.

#### **42 дугаар зүйл.Өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах**

42.1.Иргэний хуулийн 537 дугаар зүйлд заасны дагуу өв нээгдсэн газрын нотариатч өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авч болно.

42.2.Нотариатч өвлүүлэгч нь банкнд хадгаламжтай эсэхийг шалгаж, хадгаламж гэрээслэгдсэн бол энэ тухай өвлөгчид мэдэгдэнэ.

42.3.Өвлүүлэгчийн эд хөрөнгө, түүний зарим хэсэг нь өв нээгдсэн газраас өөр газар байгаа бол нотариатч түүнийг хамгаалах арга хэмжээ авна.

42.4.Нотариатч нь өвлөгдөх эд хөрөнгийг бүртгэж, хадгалагч томилох бөгөөд бүртгэл хийхэд хоёроос доошгүй гэрчийг байлцуулан өвлөгдөх эд хөрөнгө, түүний оршин байгаа газар, бүртгэл хийсэн он, сар, өдөр, оролцогч, эд хөрөнгө-хадгалахаар хүлээж авсан этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, хаяг зэргийг тэмдэглэж, бүртгэлийг гурваас доошгүй хувь үйлдэж оролцогчдоор гарын үсэг зуруулна.

42.5.Өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах боломжгүй бол нотариатч энэ тухай акт үйлдэж сонирхогч талуудад мэдэгдэнэ.

42.6.Өвлөгч нь өв хүлээн авахаас татгалзсан тохиолдолд нотариатч эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээг дуусгавар болгох тухай бусад өвлөгчид мэдэгдэх бөгөөд бусад өвлөгчид өв хүлээн авахаас татгалзвал өвлөгдөх хөрөнгийг төрийн зохих байгууллагын өмчлөлд шилжүүлж гэрчилгээ олгоно.

#### **43 дугаар зүйл.Өвлөх эрхийн гэрчилгээ олгох**

43.1.Өв нээгдсэн газрын нотариатч өвлөгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн Иргэний хуульд заасны дагуу өвлөх эрхийн гэрчилгээ олгоно.



43.2.Хууль ёсны өвлөгчид өвлөх эрхийн гэрчилгээ олгохдоо дараахь баримт бичгийг үндэслэнэ:

43.2.1.хууль ёсны өвлөгч болохыг нотлох баримт бичиг;

43.2.2.өвлүүлэгчийн нас барсны гэрчилгээ, сураггүй алга болсонд тооцсон болон нас барсан гэж зарласан бол энэ тухай шүүхийн шийдвэр;

43.2.3.өвлөгдөх эд хөрөнгийн оршин байгаа газар, бүрэлдэхүүн, тоо хэмжээ, тэдгээр нь өвлүүлэгчийн өмч болохыг нотлох баримт бичиг;

43.2.4.хууль ёсны өвлөгчөөр тогтоосон шүүхийн шийдвэр;

43.2.5.өвлөгчийн бичгээр гаргасан хүсэлт, түүний оршин суугаа баг, хорооны Засаг даргын тодорхойлолт.

43.3.Өвлөгч нь Иргэний хуулийн 528.5-д заасны дагуу өв хүлээн авахаас татгалзвал нотариатч хүсэлтийг нь гэрчилж түүнд ногдох хэсгийг хууль ёсны бусад өвлөгчид санал болгож зөвшөөрвөл өвлөх эрхийн гэрчилгээ олгоно.

43.4.Өвлөх эрхийн гэрчилгээнд өвлөгдөх эд хөрөнгө, ногдох хэсгийг тодорхой заах бөгөөд түүнийг тогтоохдоо Иргэний хуулийн 522, 531, 533 дугаар зүйлийг баримтална.

43.5.Өвлөгч нь насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй бол өвлөх эрхийн гэрчилгээг болон хууль ёсны төлөөлөгч /эцэг /эх/, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-д нь олгож, энэ тухай тусгайлан тэмдэглэл үйлдэнэ.

43.6.Өвлөгдөх эд хөрөнгө барьцаанд байгаа нөхцөлд өвлөх эрхийн гэрчилгээг уг эд хөрөнгийг барьцаалсан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн өвлөгчид олгоно.

43.7.Эрх бүхий байгууллага өвлөгдөх эд хөрөнгийг битүүмжилсэн бол уг өвлөгдөх эд хөрөнгийг битүүмжлэлээс чөлөөлөгдтөл өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг хориглоно.

43.8.Өвлөх эрхийн гэрчилгээний загварыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.



#### **44 дүгээр зүйл. Гарын үсэг гэрчлэх**

44.1. Нотариатч хуульд нийцсэн баримт бичигт зурсан гарын үсгийн үнэн зөвийг гэрчилнэ.

44.2. Нотариатч хуулийн этгээдийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтны гарын үсгийг гэрчлэх бол тухайн байгууллагын тамга, тэмдэг дарагдсан эсэхийг нягтална.

44.3. Хэлгүй, дүлнй, ярьж чаддаггүй буюу монгол хэл мэддэггүй хүний гарын үсгийн үнэн зөвийг гэрчлэхдээ үйлчлүүлэгчийн иргэний баримт бичгийг шалгаж гарын үсэг зурахад гэрч оролцуулах эсэхийг асууж тодруулах ба шаардлагатай гэж үзвэл гэрч оролцуулж тэмдэглэл хөтөлнө.

44.4. Үйлчлүүлэгч биечлэн ирж тухайн баримт бичиг болон нотариатын үйлдлийн бүртгэлийн дэвтэрт гарын үсгээ зурна.

#### **45 дугаар зүйл. Нотариатчийн мэдэгдэх хуудас, түүний агуулга**

45.1. Төлбөрийг нотолсон баримт бичгийг үндэслэн төлбөр төлөгчөөс мөнгө, эд хөрөнгийг гаргуулахаар талууд харилцан тохиролцож байгуулсан гэрээг гэрчлэхдээ нотариатч мэдэгдэх хуудас үйлдэнэ.

45.2. Энэ хуулийн 45.1-д заасан мэдэгдэх хуудас үйлдэхдээ нотариатч дараахь нөхцөлийг харгалзана:

45.2.1. баримт бичиг нь төлбөр төлөгчөөс төлбөр авагчид төлбөр төлөх нь маргаангүй гэдгийг нотолж байгаа эсэх;

45.2.2. нэхэмжлэл гаргах эрх үүссэнээс хойш гурван жилийн хугацаа өнгөрсөн эсэх.

45.3. Нотариатчийн мэдэгдэх хуудсанд дараахь зүйлийг заана:

45.3.1. мэдэгдэх хуудас олгож байгаа нотариатчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, харьяалах тойрог;

45.3.2. ямар баримт бичгийг үндэслэж мэдэгдэх хуудас үйлдэж байгаа;

45.3.3. төлбөр авагч, төлбөр төлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, ажлын болон оршин суугаа газрын хаяг, аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаяг,



банкин дахь харилцах дансны дугаар, улсын бүртгэлийн дугаар;

45.3.4.төлбөр гаргуулах хугацаа;

45.3.5.төлбөрийн хэмжээ, шаардлагын зүйл, хэрэв мэдэгдэх хуудас үйлдэхэд үндэс болгосон баримт бичигт заасан бол хүү, торгуулийн хэмжээ;

45.3.6.нотариатын үйлчилгээний хөлс, зардлын хэмжээ;

45.3.7.мэдэгдэх хуудас үйлдсэн он, сар, өдөр, дугаар.

45.4.Нотариатч мэдэгдэх хуудсыг хэвлэмэл хуудас дээр үйлдэж, тамга дарж, гарын үсэг зурна.

45.5.Нотариатчийн мэдэгдэх хуудсанд заасан төлбөрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд<sup>1</sup> заасан журмын дагуу гаргуулна.

#### **46 дугаар зүйл.Гэрээ, хэлцэл гэрчлэх**

46.1.Нотариатч хуульд заасан дараахь гэрээ, хэлцлийг гэрчилнэ:

46.1.1.үл хөдлөх эд хөрөнгийг бусдад шилжүүлэх хэлцэл;

46.1.2.гэрлэгчдийн эд хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээ;

46.1.3.орон сууц дангаар өмчлөх эрх үүсгэх хэлцэл;

46.1.4.өөрт бэлэн байгаа бүх эд хөрөнгө, түүний тодорхой хэсгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, хязгаартайгаар эзэмшүүлэх, ашиглуулах /узуфрукт/ гэрээ;

46.1.5.тэжээн тэтгэх гэрээ;

46.1.6.эрх шилжүүлэх гэрээ;

46.1.7.зээлийн гэрээ;

46.1.8.хувьцаа, бусад үнэт цаасыг бусдын өмчлөлд шилжүүлэх гэрээ.

46.2.Нотариатч гэрээ, хэлцлийг гэрчлэхдээ хуульд нийцсэн болон

<sup>1</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

талуудын хүсэл зоригийн илэрхийлэл мөн эсэхийг дор дурдсаны дагуу нягтална:

46.2.1. талууд тэгш эрхийн үндсэн дээр гэрээ, хэлцэл байгуулсан эсэх;

46.2.2. бусдын дарамт, шахалт болон бусад хүчин зүйлсийн нөлөөлөлд автаагүй эсэх;

46.2.3. агуулга нь үйлчлүүлэгчийн хүсэл зоригийг бүрэн илэрхийлж чадсан эсэх;

46.2.4. үүсэх үр дагавар, үр дүнд бодитой хандаж чадсан эсэх.

46.3. Энэ хуулийн 46.2-т заасан нөхцөл байдлын аль нэг нь зөрчөгдсөн бол нотариатч гэрээ, хэлцлийг гэрчлэхээс татгалзана.

46.4. Гэрээ, хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийж байгаа бол төлөөлөгчийн бүрэн эрх, итгэмжлэл хуульд заасан шаардлага хангасан эсэхийг нягтална.

46.5. Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс хийж байгаа гэрээ, хэлцлийг гэрчлэхдээ түүнийг хуулийн дагуу төлөөлж байгаа этгээдийн эрх хэмжээ нь гэрээ, дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрт тусгагдсан эсэхийг шалгана.

46.6. Нотариатч гэрээ, хэлцлийг гэрчлэхдээ түүний агуулга, гарах үр дагавар, үүргээ биелүүлээгүй нөхцөлд хүлээх хариуцлага зэргийг бүрэн гүйцэд ойлгосон эсэхийг талуудаас тодруулна.

46.7. Хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, эрхийг бусдад шилжүүлэх гэрээ, хэлцлийг гэрчлэхдээ уг хөрөнгө, эрх нь тухайн этгээдийн хууль ёсны өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа эсэхийг нотлох эрхийн баримт бичгийг, хуулийн этгээдийн хувьд үүсгэн байгуулах гэрээ, дүрмийг үндэслэл болгоно.

46.8. Зохих байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох гэрээ, хэлцэлд нэмэлт, өөрчлөлт оруулсан, хугацааг сунгасан, цуцалсан, дуусгавар болгосныг гэрчлэхдээ гэрээний талуудын хүсэлтийг үндэслэн бие даасан нотариатын үйлдэл хийх бөгөөд ингэхдээ анхдагч гэрээг үндэслэж түүний хуулбарыг нотариатын баримтад хавсаргана.

46.9. Үл хөдлөх эд хөрөнгийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт



оруулах болон дундын өмчлөлд байгаа үл хөдлөх эд хөрөнгийг бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэх гэрээ, хэлцлийг гэрчлэхдээ түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөж болох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрлийг үндэслэнэ.

46.10.Нотариатч гэрчилсэн гэрээ, хэлцлийн хувийг талуудад өгч, өөрт үлдэх хувьд холбогдох баримт бичгийг хавсаргаж, архивт хадгална.

#### **47 дугаар зүйл. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбогдох баримт бичиг гэрчлэх**

47.1.Нотариатч эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхтэй холбогдсон баримт бичгийг гэрчилж болно.

47.2.Энэ хуулийн 47.1-д заасан баримт бичгийг гэрчлэхдээ тухайн баримт бичиг нь Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд<sup>4</sup> заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягтална.

#### **48 дугаар зүйл. Гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс гишүүнд ногдох хэсгээ өмчлөх эрхийг гэрчлэх**

48.1.Бичгээр байгуулсан гэрээг үндэслэн нотариатч гэрлэгчдийн эд хөрөнгийн эрхийг гэрчилж болох бөгөөд гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс гишүүний өөрт ногдох хэсгийг өмчлөх эрх нь тухайн өдөр гэрлэгчдийн дундын өмчлөлд байсан эд хөрөнгөд хамаарах бөгөөд уг эд хөрөнгийн шинж байдлыг гэрээнд тодорхой тусгана.

48.2.Нотариатч гэрлэгчдийн өөрт ногдох хэсгийн өмчлөх эрхийг гэрчлэхдээ гэрлэлтийн гэрчилгээ, гэрлэлт цуцалсан тухай шүүхийн шийдвэр, нас барсны гэрчилгээ, сураггүй алга болсонд тооцсон, эсхүл нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр, гэрлэгчдийн дундаа үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг нотолсон баримт бичгийг үндэслэнэ.

48.3.Үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө гэрлэгчдийн дундын хөрөнгийн бүрэлдэхүүнд байгаа эсэхийг гэрчлэхдээ уг эд хөрөнгийг зохих байгууллагад бүртгүүлсэн баримт бичиг, татвар, хураамж төлсөн баримт нотолгоог үндэслэл болгоно.

48.4.Банкны зээлээр орон сууц барьсан букуу их засвар хийсэн бол гэрлэгч тус бүрт ногдох хэсгийг өмчлөх эрхийг зээл олгогчийн

<sup>4</sup> Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 25 дугаарт нийтлэгдсэн.



лавлагааг үндэслэн гэрчилнэ.

48.5. Гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан бол тэдний дундын үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгөөс эхнэр буюу нөхрийн хүсэлтээр түүнд ногдох хэсгийн өмчлөх эрхийг энэ тухай өв залгамжлагчид мэдэгдэн тэмдэглэл хөтөлж, гарын үсэг зуруулсны дараа гэрчилнэ.

48.6. Энэ хуулийн 48.5-д заасан мэдэгдэлд эхнэр буюу нөхөрт олгох эд хөрөнгийн бүрэлдэхүүнийг заана.

48.7. Нас барагчийн эхнэр буюу нөхөр нь түүний насанд хүрээгүй хүүхэд болон эрх зүйн чадамжгүй өв залгамжлагчийн хууль ёсны төлөөлөгч биш бол энэ хуулийн 48.5-д заасан мэдэгдлийг тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч /эцэг, /эх/, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-д өгнө.

48.8. Мэдэгдлийг шуудангаар явуулж болох бөгөөд хэрэв өв залгамжлагч өөрөө биечлэн ирсэн бол нотариатч түүнд амаар мэдэгдэж, нас барагчийн эхнэр буюу нөхрийн өргөдөлтэй танилцуулан гарын үсэг зуруулна.

#### **49 дүгээр зүйл. Баримт бичгийн хуулбар гэрчлэх**

49.1. Баримт бичгийн бүрэн буюу хэсэгчилсэн хуулбарын агуулга нь хуульд харшлаагүй бол нотариатч хуулбарыг эх хувьтай нь тулган шалгасны үндсэн дээр гэрчилнэ.

49.2. Өөр өөр утга санаа агуулсан баримт бичгийн аль нэг хэсгийн хуулбарын үнэн зөвийг гэрчилж болох бөгөөд ийнхүү гэрчлэхдээ үндсэн агуулгыг илэрхийлсэн хэсгийг заавал хамт гэрчилнэ.

49.3. Анхны хуулбар урьд нь нотариатчаар гэрчлэгдсэн, эсхүл уг баримт бичгийг олгосон иргэн, хуулийн этгээд түүний үнэн зөвийг тодорхойлсон тохиолдолд баримт бичгийн хуулбарын хуулбарыг гэрчилнэ.

#### **50 дугаар зүйл. Хуулийн этгээд үүсгэн байгуулах баримт бичиг гэрчлэх**

50.1. Нотариатч хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан баримт бичгийг гэрчлэхдээ үүсгэн байгуулагчийн иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг, хуулийн этгээдийг үүсгэн байгуулах шийдвэр зэргийг үндэслэл болгоно.

50.2. Нотариатч Иргэний хуулийн 33 дугаар зүйлд заасан хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан баримт бичгийг гэрчлэхдээ тухайн баримт



бичиг нь Компанийн тухай<sup>5</sup>, Нөхөрлөлийн тухай<sup>6</sup>, Хоршооны тухай<sup>7</sup>, Төрийн бус байгууллагын тухай хуульд<sup>8</sup> заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягтална.

## НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

### 51 дүгээр зүйл. Нотариатын үйл ажиллагаанд тавих хяналт

51.1. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Танхимын дэргэдэх Сахилгын зөвлөл /цаашид "Сахилгын зөвлөл" гэх/ нотариатчдын үйл ажиллагаанд хяналт тавина.

### 52 дугаар зүйл. Нотариатын баримт бичгийг шалгах

52.1. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нотариатын баримт бичигт шалгалт хийх бөгөөд шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж болно.

### 53 дугаар зүйл. Нотариатчийн ёс зүйн дүрэм

53.1. Нотариатч нь нотариатчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

53.2. Нотариатчийн ёс зүйн дүрмийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

53.3. Нотариатчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн нотариатчид сахилгын шийтгэл ногдуулна.

### 54 дүгээр зүйл. Сахилгын шийтгэл

54.1. Сахилгын зөвлөл нотариатчийн гаргасан зөрчлийн шенж байдлыг харгалзан сануулах арга хэмжээ авна.

54.2. Энэ хуулиар тогтоосон журам, нотариатчийн ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн нь захиргааны болон эрүүгийн хариуцлага

<sup>5</sup> Компанийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 34 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup> Нөхөрлөлийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 8-9 дугаарт нийтлэгдсэн.

<sup>7</sup> Хоршооны тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

<sup>8</sup> Төрийн бус байгууллагын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1997 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

хүлээлгэхээргүй бол Сахилгын зөвлөл нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гаргана.

54.3.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Сахилгын зөвлөлийн саналыг үндэслэн нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

54.4.Нотариатч Сахилгын зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гомдол гаргаж болно.

54.5.Энэ хуулийн 16.2, 16.3-т заасан нотариатын үүрэг гүйцэтгэгч мөн хуулийн 54.1-д заасан зөрчил гаргасан бол холбогдох төрийн захиргааны байгууллага сахилгын шийтгэл ногдуулна.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“11.1.3.тусгай зөвшөөрөл хүсэгч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар.”.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АРБИТРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Арбитрын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсгийн "хэлэлцээрийг монгол хэл дээр орчуулж, гэрчлүүлэн" гэснийг "хэлэлцээрийн албан ёсны орчуулгыг" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"23.2.2.импортлогч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;"

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АЖИЛЛАХ ХҮЧ ГАДААДАД ГАРГАХ, ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТЭН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн дараахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### 1/6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт:

"6.3.2.аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;"

#### 2/8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалт:

"8.2.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;"

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн дараахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### 1/18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалт:

"18.2.2.тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн



гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар/”.

**2/22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалт:**

“22.1.1.хайгуулийн тусгай зөвшөөрлийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар/”.

**3/28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт:**

“28.1.1.ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар/”.

**2 дугаар зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.3.1 дэх заалтын “нотариатаар гэрчлүүлсэн” гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 4 дэх хэсэг нэмсүгэй:

“4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан этгээд нь хөрөнгө оруулалтын гэрээг бүртгэхдээ гэрээний эх хувийг шаардан авч болно.”

**2 дугаар зүйл.**Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн



15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "гэрээний нотариатаар батлагдсан хуулбарыг" гэснийг "гэрээг" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### **МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.1, 20.3.3 дахь заалтын "нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар" гэснийг өмнө "хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол" гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### **ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

"58.3.1.хүүхэд үрчлэн авахыг хүсэгч /нөхөр, эхнэртэй бол хамтарч гаргасан/-ийн нотариатчаар гэрчлүүлсэн хүсэлт, хэрэв уг хүсэлтийг гадаад хэл дээр гаргасан бол түүний албан ёсны орчуулга;"



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Иргэний бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийн "нотариатаар гэрчлүүлсэн орчуулгын хуулбар" гэснийг "орчуулга" гэж, мөн зүйлийн 13.12 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсгийн "нотариатаар гэрчлүүлсэн" гэснийг "албан ёсны" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ БА ГАЗРЫН  
КАДАСТРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалтын "нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээ" гэснийг "улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар" гэж өөрчилсүгэй.



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД  
ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2/гэр бүл нь гадаадын иргэн бол энэ тухай баримт бичгийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;”.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ  
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.1, 5.2.2 дахь заалтын “нотариатаар” гэснийг “хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх



бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар” гэж тус тус өөрчилсүгэй.”.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### **НӨХӨРЛӨЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нөхөрлөлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “Гэрээ нотариатаар гэрчлэгдсэн байна.” гэсэн 2 дахь өгүүлбэрийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### **СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.2.1.сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг байршуулах



зориулалтаар олгосон газрыг эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар.”.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.3.1.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар.”.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 16.7 дахь хэсэг нэмсүгэй:

"16.7.Энэ хуулийн 16.1.2, 20.1.2, 24.1-т заасан баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ."

**2 дугаар зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн "шийдвэр, эсхүл уг шийдвэрийн нотариатаар" гэснийг "шийдвэрийн эх хувь, эсхүл хуулбар, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар" гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Чөлөөт бүсийн тухай хуулийн 13 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 13.3 дахь хэсэг нэмсүгэй:

"13.3.Энэ хуулийн 13.2-т заасан баримт бичгийг хүлээн авч байгаа



эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ.

**2 дугаар зүйл.** Чөлөөт бүсийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2, 13.2.3 дахь заалтын "нотариатаар гэрчлүүлсэн хуулбар" гэснийг "хуулбар, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар" гэж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийн дугаарыг "13.4" гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭД ХӨРӨНГИЙН БУСАД ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 13.10 дахь хэсэг нэмсүгэй:

"13.10. Гэрээ, хэлцэлд оролцогч талууд нотариатчаар гэрчлэгдээгүй аливаа гэрээ, хэлцэл, баримт бичгийн үнэн зөвийн баталгааг хангаж, түүнээс үүсэх хууль зүйн үр дагаврыг бүрэн хариуцна."

**2 дугаар зүйл.** Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн "гэрээний" гэсний дараа, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн "хэлцлийн" гэсний дараа, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн "баримтын" гэсний дараа, 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн "зөвшөөрлийг" гэсний дараа, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн "бичгийн" гэсний дараа "эх хувь, эсхүл" гэж тус тус нэмсүгэй.



**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН  
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн "орчуулуулж, нотариатчаар гэрчлүүлсэн байна" гэснийг "орчуулуулсан байна" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХУУЛЬЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1, 13.3.2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"13.3.1. Монгол Улсын иргэний үнэмлэх, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний хувьд гадаад улсын паспорт болон түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч

байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;”

“13.3.2.эрх зүйн бакалаврын болон түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;”.

**2 дугаар зүйл.**Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтын “Нотариатын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 6” гэснийг “Нотариатын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3, 18.1.6” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.3.1.иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;”.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1 дэх заалтын "нотариатаар гэрчлүүлсэн хуулбар" гэснийг "эх хувь" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4.2 дахь заалтын "нотариатаар гэрчлүүлсэн" гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6.1 дэх заалтын "нотариатаар гэрчлүүлсэн хуулбар" гэснийг "эх хувь" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.2 дахь заалтын "нотариатаар гэрчлүүлсэн" гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хувиргасан амьд организмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"6.4.5.иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар, аж ахуйн нэгж, байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 1997 оны 5 дугаар сарын 02-ны өдөр баталсан Нотариатын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан Нотариатын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

## МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Хөгжлийн банк /цаашид "Хөгжлийн банк" гэх/-ны үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Хөгжлийн банкны тухай хууль тогтоомж

2.1.Хөгжлийн банкны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульцааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

#### 4 дүгээр зүйл.Хөгжлийн банк

4.1.Хөгжлийн банк нь энэ хуулийн 8.1-д заасан Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилго бүхий энэ хуульд заасан үйл ажиллагааг эрхлэх тусгайлсан чиг үүрэгтэй ашгийн төлөө төрийн өмчит хуулийн этгээд байна.

4.2.Хөгжлийн банкныг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийг Засгийн газар гаргаж, Улсын Их Хуралд танилцуулна.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



## **5 дугаар зүйл.Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө**

5.1.Хөгжлийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгө дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

5.1.1.улсын төсвөөс хуваарилсан Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө;

5.1.2.хуульд заасан бусад эх үүсвэр.

5.2.Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн доод хэмжээг Засгийн газар тогтооно.

## **6 дугаар зүйл.Хөгжлийн банкны зарчим**

6.1.Хөгжлийн банк нь үйл ажиллагаандаа дараахь зарчмыг баримтална:

6.1.1.үйл ажиллагаагаа тогтвортой явуулах;

6.1.2.хараат бус байх;

6.1.3.ашигтай ажиллах;

6.1.4.ил тод байх;

6.1.5.хариуцлагатай байх.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **7 дугаар зүйл.Хөгжлийн банкны эрхлэх үйл ажиллагаа**

7.1.Хөгжлийн банк дараахь үйл ажиллагааг эрхэлнэ:

7.1.1.зээл олгох, авах;

7.1.2.зээлдэгчийн харилцах данстай холбоотой гадаад, дотоод төлбөр тооцоо хийх;

7.1.3.өөрийн нэрийн өмнөөс зээлийн баталгаа, батлан даалт гаргах;

7.1.4.үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;



7.1.5.гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах;

7.1.6.зээл худалдах, санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах;

7.1.7.хөрөнгө, өр төлбөрийн зүй зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

## **8 дугаар зүйл.Зээл олгох**

8.1.Хөгжлийн банк нь Улсын Их Хурлын баталсан Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээл олгох бөгөөд санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Улсын Их Хурал жил бүрийн хаврын чуулганаар батална.

8.2.Зээл олгох шийдвэрийг Хөгжлийн банкны актив-пассивийн болон эрсдэлийн удирдлагын нэгжийн дүгнэлтийг үндэслэн зээлийн хороо гаргана.

8.3.Хөгжлийн банкнаас олгох зээл нь дараахь шаардлагыг хангасан байна:

8.3.1.банкуудын зээлийн дундаж хүүгээс доогуур хүүтэй байх;

8.3.2.зөвхөн мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэсэн байх;

8.3.3.зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр нь үр ашигтай байх;

8.3.4.зээлийн эргэн төлөгдөх хуваарь тодорхой байх;

8.3.5.зээл нь барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийн бусад арга хэрэгслээр хангагдсан байх;

8.3.6.зээл хөнгөлттэй нөхцөлтэй байх.

## **9 дүгээр зүйл.Төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх**

9.1.Энэ хуулийн 8.1-д заасан төсөл, хөтөлбөрт Засгийн газраас баталгаа гаргасан гэхийг үндэслэн Хөгжлийн Банк уг төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлж болно. Засгийн газрын баталгаа нь зөвхөн уг төсөл, хөтөлбөр



дотор Засгийн газрын эзэмших, өмчлөх хувиар хязгаарлагдана. Засгийн газрын баталгааг зөвхөн даатгагдсан төсөл, хөтөлбөрийн зээлд гаргана.

9.2.Засгийн газраас баталгаа гаргасан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

9.3.Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн, Засгийн газрын баталгаа гаргаснаас бусад хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл батална.

9.4.Хөгжлийн банкны санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг төр болон хувийн хэвшлийн байгууллага хамтран хэрэгжүүлж болно.

### **10 дугаар зүйл.Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрт тавих шаардлага**

10.1.Хөгжлийн банкнаас сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр нь дараахь шаардлагыг хангасан байна:

10.1.1.Засгийн газрын баталсан Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий салбарт хамаарах;

10.1.2.төсөл, хөтөлбөрийн зураг төсөл, төсөв, техник, эдийн засгийн үнэлгээ хийгдсэн байх;

10.1.3.эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, эсхүл олон улсын болон Европын холбооны стандартын шаардлагад нийцсэн экспортын болон импортыг орлох нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн байх;

10.1.4.зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээл авах үндэслэл, төсөл, хөтөлбөрийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг олон улсад тогтсон мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний аргачлал, шалгуурын дагуу тооцсон байх;

10.1.5.төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг тухайн зээл бүрэн төлөгдөж дуусах хүртэл зээлийн барьцаа хөрөнгөд тооцсон байх.

### **11 дүгээр зүйл.Зээл авах**

11.1.Хөгжлийн банк нь хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын зөвшөөрснөөр гадаад, дотоод эх үүсвэрээс зээл авч болно.



## **12 дугаар зүйл.Төлбөр тооцоо хийх**

12.1.Хөгжлийн банк нь өөрийн харилцагчид төлбөр тооцооны бүх төрлийн үйлчилгээг түүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үзүүлнэ.

12.2.Хөгжлийн банк нь харилцагчийн даалгавраар түүний харилцах дансны үлдэгдэлд багтаан мөнгөн хөрөнгийг шилжүүлэх гүйлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

12.3.Төлбөр тооцооны үйлчилгээний хөлсийг Хөгжлийн банк өөрөө тогтооно.

12.4.Хөгжлийн банк нь банк хоорондын гүйлгээг Монголбанк дахь харилцах дансаараа дамжуулан хийнэ.

12.5.Хөгжлийн банкны төлбөр тооцооны үйл ажиллагааг Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай<sup>7</sup> хуульд заасан журмын дагуу зохицуулна.

## **13 дугаар зүйл.Зээлийн баталгаа, батлан даалт гаргах**

13.1.Хөгжлийн банк нь энэ хуулийн 24.1-д заасан хязгаарлалтын хүрээнд дангаар болон бусад этгээдтэй хамтран гуравдагч этгээдэд зээлийн баталгаа, батлан даалт гаргаж болно.

## **14 дүгээр зүйл.Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах**

14.1.Энэ хуулийн 24.1-д заасан хязгаарлалтын хүрээнд хөрөнгийн болон мөнгөний зах зээл дээр арилжаалагдах үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах шийдвэрийг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Хувь нийлүүлэгчдийн хурал гаргана.

## **15 дугаар зүйл.Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах**

15.1.Хөгжлийн банкны гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулахтай холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

<sup>7</sup> Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БАНКНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 16 дугаар зүйл.Хөгжлийн банкны удирдлага

16.1.Хөгжлийн банкны эрх барих дээд байгууллага нь Хувь нийлүүлэгчдийн хурал, түүний чөлөөт цагт Төлөөлөн удирдах зөвлөл байна.

16.2.Хөгжлийн банкны хувь нийлүүлэгч нь Монгол Улсын Засгийн газар байх бөгөөд Хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

### 17 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл

17.1.Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн гурав нь хараат бус гишүүн байна.

17.2.Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Засгийн газар томилж, чөлөөлнө.

17.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн нь дараахь шаардлагыг хангасан байна:

17.3.1.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

17.3.2.ял шийтгэлгүй;

17.3.3.ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банкныг удирдахад харшлахгүй байх;

17.3.4.банк, санхүү, хууль, эдийн засаг, инженерийн дээд боловсролтой;

17.3.5.төрийн улс төрийн албан тушаал хашдаггүй байх;

17.3.6.эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон байх.

17.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус 3 гишүүнийг Монголбанк, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим,

Монголын Банкны холбоо тус тус нэр дэвшүүлж Засгийн газар томилно.

17.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн энэ хуулийн 17.3-т зааснаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

17.5.1.мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, хоёроос доошгүй жилд нь эрх бүхий албан тушаал хашсан байх;

17.5.2.төрийн улс төрийн, захиргааны, тусгай албан тушаал хашдаггүй байх;

17.5.3.Хөгжлийн банктэй бизнесийн аливаа холбоогүй байх.

17.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь бусад гишүүний адил эрх, үүрэгтэй байна.

17.7.Төлөөлөн удирдах зөвлөл нь дотоод аудитын, нэр дэвшүүлэлтийн, цалин урамшууллын дэд хороодтой байх ба дэд хороонд хараат бус гишүүн орж ажиллана.

## **18 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх**

18.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1.Хөгжлийн банкны стратегийг тодорхойлох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах;

18.1.2.Хөгжлийн банкны зээлийн бодлогыг зээлийн найдвартай эргэн төлөгдөх зарчимд тулгуурлан жил бүр тодорхойлж батлах;

18.1.3.зээл авах, үнэт цаас гаргах, худалдах, худалдан авахад Засгийн газрын саналыг авах;

18.1.4.Хөгжлийн банкны бизнес төлөвлөгөөг батлахдаа Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны саналыг авах;

18.1.5.гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, хариуцлагыг гогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүхийг эдлэн, ургамжуулгын хэмжээг тогтоох;



18.1.6.Хувь нийлүүлэгчдийн ээлжит, ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай үндэслэл бүхий саналыг хүргүүлэх;

18.1.7.Хөгжлийн банкны жилийн үйл ажиллагааны талаархи тайлан, түүнд хийсэн олон улсын аудитын дүгнэлтийг Хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж хэлэлцүүлэх;

18.1.8.Хөгжлийн банкны дотоод хяналтын нэгжийг гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулж, түүний төсөв, орон тоог батлах, удирдлага, ажилтныг томилох, үйл ажиллагааны журмыг тогтоох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

18.1.9.Хөгжлийн банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоож, хэрэгжилтэд хяналт тавих;

18.1.10.Хөгжлийн банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүү, үйл ажиллагааны талаархи хууль тогтоомж, холбогдох стандартын хэрэгжилтийг хангуулах;

18.1.11.Хөгжлийн банкны санхүүгийн тайлан тэнцэл, зарлагын болон мөнгөн хөрөнгийн хөдлөлийн тайлан, тайлбар, тодруулга бусад мэдээллийг нийтэд мэдээлэх явцад хяналт тавих;

18.1.12.Хөгжлийн банкны эзэлийн болон санхүүгийн бусад үйлчилгээний хүү, шимтгэлийн хувь хэмжээг холбогдох журмын дагуу тогтоох.

18.2.Хөгжлийн банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал сард нэгээс доошгүй удаа хуралдана.

18.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд тогтоолд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

18.4.Төлөөлөн удирдах зөвлөлийг бүх гишүүдийн гуравны хоёроос доошгүйн ирцтэйгээр хуралдуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

18.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, хуралд оролцогчдын саналын баримт бичгийн баталгаажуулсан хувийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор Хувь нийлүүлэгчид хүргүүлнэ.



## 19 дүгээр зүйл. Гүйцэтгэх удирдлага

19.1. Гүйцэтгэх удирдлага нь Хөгжлийн банкны дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор Хөгжлийн банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

19.2. Гүйцэтгэх удирдлагыг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын дагуу сонгож, Хувь нийлүүлэгчдийн хурлын зөвшөөрснөөр Төлөөлөн удирдах зөвлөл томилж, чөлөөлнө. Гүйцэтгэх удирдлагын 50-иас доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байна.

19.3. Гүйцэтгэх удирдлага нь энэ хуулийн 17.3.3-т зааснаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

19.3.1. банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, санхүүгийн салбарт 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай;

19.3.2. ял шийтгэлгүй;

19.3.3. банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон удирдлагын чадварыг хангаж ажиллах чадвартай.

19.4. Гүйцэтгэх удирдлага Компанийн тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.4.1. Хөгжлийн банкны дотоод дүрэм, журам, заавар, аргачлалыг батлах;

19.4.2. Хөгжлийн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуурыг хангаж ажиллах;

19.4.3. санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэх, төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой санхүү бүртгэл, мэдээлэл, удирдлага, зохион байгуулалтын асуудлаар холбогдох шийдвэрийг гаргах;

19.4.4. Хөгжлийн банкны зээлийн бодлого, түүний хэрэгжилттэй холбоотой асуудлаар Засгийн газар, түүний холбогдох бусад байгууллагатай шууд харилцаж, байр сууриа илэрхийлэх;

<sup>1</sup>Компанийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эхтгэлийн 1999 оны 34 дугаар нийтлэгдсэн.

19.4.5.Хөгжлийн банкны жилийн төсвийг боловсруулан батлуулж, гүйцэтгэлийг зохион байгуулах;

19.4.6.шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх;

19.4.7.Хөгжлийн банкнийг төлөөлөх, бүрэн эрхийнхээ хүрээнд зээлийн хорооны шийдвэрийг үндэслэн зээл олгох, төлбөрийн батлан даалт, Хөгжлийн банкны баталгаа гаргах гэрээ, хэлцлийг холбогдох хуулийн этгээдтэй байгуулах;

19.4.8.Хөгжлийн банкны боловсон хүчнийг сонгох, бэлтгэх, давтан сургах бодлогыг тодорхойлох, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах, цалингийн сүлжээ, урамшуулал, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох, ажлаас чөлөөлөх, урамшуулах, сахилгын арга хэмжээ авах;

19.4.9.Хөгжлийн банкны нэрийн өмнөөс холбогдох мэдээ, тайланг харилцагчаас шаардан авах, тэдний тайлан тэнцэлтэй танилцах, шалгах, хууль тогтоомжийн дагуу хөрөнгийг барьцаанд авах, дансны гүйлгээг түр хаах.

#### 19.5.Гүйцэтгэх удирдлага дараахь үүрэг хүлээнэ:

19.5.1.Хөгжлийн банкны үйл ажиллагааны хэтийн чиглэл, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, актив, пассивын удирдлагын бодлогыг тодорхойлох;

19.5.2.санхүүгийн сахилга батыг сахиулах, Хөгжлийн банкны хэвийн үйл ажиллагааг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

19.5.3.Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтын төслийн болон зээлийн шинжилгээ, үнэлгээ хийх зориулалтаар мэдээллийн сан бүрдүүлэх;

19.5.4.төсөл, хөтөлбөрийн үнэлгээний зарчмыг тогтоож, сайжруулах арга хэмжээ авах;

19.5.5.Хөгжлийн банкны зээлийн үйл ажиллагааны хяналт, шалгалтын тогтолцоог бүрдүүлэх;

19.5.6.харилцагчаас Хөгжлийн банкны өмнө хүлээсэн үүргийг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

19.5.7.Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, заавар, тушаалын хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тооцон ажиллах;



19.5.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн саналыг үндэслэн Хувь нийлүүлэгчдийн хурлаас зөвшөөрсний дагуу Хөгжлийн банкны хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж, чөлөөтэй мөнгөн хөрөнгийг зах зээлд хөрвөх чадвартай, өндөр зэрэглэлийн санхүүгийн хэрэгсэлд үр өгөөжтэй байршуулах, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

19.5.9.Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, зээлийн талаархи мэдээллийг цаг тухайд нь гаргаж, тэдгээрийн үнэн зөв байдлыг хариуцах;

19.5.10.Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, олгосон зээлийн хэмжээ, гаргасан үнэт цаас, түүний борлуулалтын хэмжээ, эх үүсвэр татан төвлөрүүлэлт, үр ашгийн байдал, цаашдын төлөв хандлагын талаар санал боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувь нийлүүлэгчдийн хуралд танилцуулах;

19.5.11.Хөгжлийн банкны санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ авах;

19.5.12.хувийн ашиг сонирхолтой нь холбогдсон асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй байх;

19.5.13.Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө ажлаа тайлагнах;

19.5.14.бусад байгууллагад ажил, албан тушаал хавсран эрхлэхгүй байх.

19.6.Ээлжийн амралт эдлэх, гадаад дотоодод албан томилолтоор ажиллах, удаан хугацаагаар өвчтэй байх зэрэг тохиолдолд Гүйцэтгэх удирдлага нь Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрсөн этгээдэд өөрийн бүрэн эрхийг шилжүүлж болох бөгөөд ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

## **20 дугаар зүйл.Хөгжлийн банкны бүтэц, зохион байгуулалт**

20.1.Хөгжлийн банк нь актив-пассивийн удирдлагын, зээлийн, эрсдэлийн удирдлагын, хяналтын болон захиргааны асуудал хариуцсан үндсэн нэгжтэй байна.

20.2.Актив-пассивийн удирдлагын асуудал хариуцсан нэгж нь Хөгжлийн банкны актив, пассивын байршил, бүтэц, хугацааны байдлыг



шинжилж, түүнийг зохистой удирдлагаар хангаж ажиллана.

20.3.Зээлийн асуудал хариуцсан нэгж нь Хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлэх болон хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрт дүн шинжилгээ, үнэлгээ хийж, төсөл, хөтөлбөрийн явцад хяналт тавьж, зээл эргэн төлөгдөхөд учирч болох эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлж, Хөгжлийн банкны зээлийн багцын оновчтой бүрдүүлэлтийг хангана.

20.4.Эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан нэгж нь Хөгжлийн банкны зээлийн болон болзошгүй бусад төрлийн эрсдэлийн дүн шинжилгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хяналт тавьж ажиллана.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХОГЖЛИЙН БАНКНЫ ТАЛААРХИ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ**

### **21 дүгээр зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх**

21.1.Улсын Их Хурал Хөгжлийн банкны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1.Хөгжлийн банкны өөрийн хөрөнгөд оруулах Засгийн газрын хувь хөрөнгийн эх үүсвэрийг тогтоох, түүний хэмжээг батлах;

21.1.2.Засгийн газраас гаргах зээлийн баталгааны дээд хэмжээг тогтоох;

21.1.3.Хөгжлийн банкны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцах.

### **22 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

22.1.Засгийн газар Хөгжлийн банкны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1.Хөгжлийн банкныг үүсгэн байгуулах, түүний дүрмийг батлах;

22.1.2.Хөгжлийн банкинд бүтцийн өөрчлөлт хийх, өөрчлөн байгуулах;

22.1.3.Хөгжлийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх;



22.1.4.Хөгжлийн банкинд зээлийн баталгаа гаргах;

22.1.5.Хөгжлийн банкны зээлийн бодлого, түүний хэрэгжилттэй холбоотой асуудлаар банк, эрх бүхий бусад байгууллагатай шууд харилцаж, байр сууриа илэрхийлэх;

22.1.6.Хөгжлийн банкны буцаан худалдан авах нөхцөлтэй гаргасан урт хугацаат үнэт цаасыг худалдан авах, хөрөнгө оруулалт хийх;

22.1.7.Хөгжлийн банкны жилийн үйл ажиллагааны талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг хэлэлцэж батлах;

22.1.8.аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

22.1.9.үнэт цаас худалдан авах шийдвэр гаргах;

22.1.10.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг 3 хүртэл жилийн хугацаагаар томилох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, чөлөөлөх;

22.1.11.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийг тогтоох, хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоох.

### **23 дугаар зүйл.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

23.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөгжлийн банкны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1.Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийг бүрдүүлэх зорилгоор улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгө, Засгийн газраас гаргах зээлийн баталгаатай холбоотой тооцооллыг хянах, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн санал боловсруулж Засгийн газарт хэлэлцүүлэх;

23.1.2.Хөгжлийн банкинд бүтцийн өөрчлөлт хийх, өөрчлөн байгуулах, татан буулгах талаар санал боловсруулж Засгийн газарт оруулах;

23.1.3.Хөгжлийн банкнд мэдэгдэл санхүүгийн шалгуур үзүүлэлтийг тогтоох.



**ТАВДУГААР БҮЛЭГ  
ХОГЖЛИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯЗГААРЛАЛТ,  
ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО**

**24 дүгээр зүйл.Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалт**

24.1.Хөгжлийн банкны үйл ажиллагаанд дараахь хязгаарлалт тавигдана:

24.1.1.зээл, зээлтэй адилтгах актив хөрөнгийн нийт дүн нь өөрийн хөрөнгийг 50 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байх;

24.1.2.зээлийн баталгаа, батлан даалт, үнэт цаасны нийт дүнгийн нийлбэр нь өөрийн хөрөнгийг 50 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байх.

**25 дугаар зүйл.Хөгжлийн банкны дотоод хяналт**

25.1.Хөгжлийн банк нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шууд удирдлагад үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байна.

25.2.Дотоод хяналтын нэгж нь дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

25.2.1.Хөгжлийн банкны удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах;

25.2.2.хувь нийлүүлэгчийн санал, гомдлын дагуу Хөгжлийн банкны санхүүгийн үйл ажиллагааг шалгах;

25.2.3.батлагдсан хуваарийн дагуу ээлжит болон ээлжит бус шалгалтыг явуулах;

25.2.4.Хөгжлийн банкны санхүүгийн баримтад хяналт, шалгалт хийх, тайлбар, лавлагаа гаргуулж авах;

25.2.5.шаардлагатай баримт бичгийг Хөгжлийн банкны харилцагчаас гаргуулан авах;

25.2.6.хувь нийлүүлэгчийг зайлшгүй шаардлагатай мэдээллээр хангах.

## **26 дугаар зүйл. Хянан шалгагч**

26.1. Хөгжлийн банк нь хянан шалгагчтай байх бөгөөд хянан шалгагч нь энэ хууль болон гэрээний дагуу тус банкны эх үүсвэрийг ашиглаж байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийнэ.

26.2. Хянан шалгагч нь дараахь эрхтэй:

26.2.1. төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн байр, албан тасалгаа бусад холбогдох газарт нэвтрэн орох;

26.2.2. төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн данс бүртгэл, тайлан тэнцэл, санхүүгийн баримтад хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа болон шаардлагатай бусад материалыг гаргуулж авах;

26.2.3. төсөл, хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцан явцын тайлан, холбогдох саналаа Хөгжлийн банкны удирдлагад танилцуулах.

26.3. Хянан шалгагчийн бүрэн эрхийн хугацаа, эрх, үүргийг энэ хуульд нийцүүлэн Хөгжлийн банкны дүрмээр тогтооно.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

### **27 дугаар зүйл. Хөгжлийн банкны нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн тайлан**

27.1. Хөгжлийн банкны санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу улирал тутам гаргаж, жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргуулна.

27.2. Хөгжлийн банкны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд хоёр жилд нэгээс доошгүй удаа Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр сонгосон олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар аудит хийлгэж, дүгнэлтийг Улсын Их Хуралд танилцуулна.

27.3. Хөгжлийн банкны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай<sup>4</sup> хуулийн 10 дугаар зүйлд заасан бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

<sup>4</sup> Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 4 дугаарт нийтлэгдсэн.

27.4.Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Хөгжлийн банкны гүйцэтгэх удирдлага хариуцна.

27.5.Хөгжлийн банк нь холбогдох тайлан, мэдээллийг Монголбанкны баталсан загвар, маягтын дагуу гаргаж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд тогтмол тус тус хүргүүлнэ.

27.6.Хөгжлийн банк төрийн эрх бүхий байгууллагаас тавьсан хүсэлтийн дагуу шаардлагатай мэдээллийг зохих журмын дагуу гаргаж өгч болно.

## **28 дугаар зүйл.Хөгжлийн банкны тайланг нийтэд мэдээлэх**

28.1.Хөгжлийн банкны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, энэ хуулийн 27.2-т заасан аудитын тайланг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ ХАРИУЦЛАГА**

### **29 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

29.1.Хөгжлийн банкны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд шүүгч, эсхүл холбогдох улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэлийг ногдуулна:

29.1.1.энэ хуулийн 8.3, 10.1-д заасныг зөрчсөн албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, эрх бүхий албан тушаалтан нь ажлаас халах;

29.1.2.энэ хуулийн 24.1-д заасныг зөрчсөн бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, эрх бүхий албан тушаалтан нь ажлаас халах;

29.1.3.энэ хуулийн 26.1-д заасан хяналт шалгалтад саад учруулсан бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;



29.1.4.төлбөр тооцооны баримтыг нуун дарагдуулсан буюу гүйлгээг саатуулсан ажилтан, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, эрх бүхий албан тушаалтан нь ажлаас халах;

29.1.5.тайлан тэнцэл, мэдээ баримтыг зохих хууль, журмын дагуу гаргаж өгөөгүй буюу энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу холбогдох байгууллагад хүргүүлээгүй, нийтэд мэдээлэх санхүүгийн тайланг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нийтэд мэдээлээгүй бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, эрх бүхий албан тушаалтан нь ажлаас халах, гүйцэтгэх удирдлагад сануулах;

29.1.6.нийтлүүлсэн тайлан, мэдээлэлд хуурамч, худал, ташаа мэдээлэл агуулагдсан бол уг тайлан, мэдээллийг баталгаажуулсан Гүйцэтгэх захирал, эрх бүхий бусад албан тушаалтныг тус бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, эрх бүхий албан тушаалтан нь ажлаас халах.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасан торгуулийн орлогыг улсын төсөвт оруулна.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төв Банк /Монголбанк/-ны тухай хуульд дор дурдсан агуулгатай 2<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

**"2<sup>1</sup> дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Банкны тухай хуульд дор дурдсан агуулгатай 2<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

**"2<sup>1</sup> дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

2<sup>1.1</sup>.Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "зарцуулалттай" гэсний дараа "болон Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд заасан Хөгжлийн банкны үйл ажиллагаатай" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3.5 дахь хэсэг нэмсүгэй:

"3.5. Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6.4 дэх хэсэг нэмсүгэй:

“6.4.Жижиг, дунд үйлдвэрийн зээлийн баталгааны тухай асуудлыг хуулиар тусгайлан зохицуулна.”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.3.Засгийн газар Монгол Улсын Хөгжлийн банкны тухай, Концессын тухай хуульд заасны дагуу улсын хөгжилд тэргүүлэх ач холбогдолтой, эдийн засаг, нийгмийн өндөр үр ашигтай томоохон төсөл, хөтөлбөрт зээлийн баталгаа гаргаж болно.”

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2011 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүний хөгжлийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар  
хот

### Зээлийн баталгааны дээд хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Хөгжлийн банкинд гаргах зээлийн баталгааны дээд хэмжээг Монгол Улсын 2011 оны төсвийн жилд дотоодын нийт бүтээгдэхүүний 24.7 хувиас, Монгол Улсын 2012 оны төсвийн жилд дотоодын нийт бүтээгдэхүүний 18.8 хувиас хэтрэхгүй байхаар тус тус тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 02 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар  
хот

### Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

1.Монгол Улсын Их Хурлын шийдвэрт заасан дараахь төсөл, хөтөлбөрийг Хөгжлийн банкны эзэлийн санхүүжилтээр 2011 оноос хэрэгжүүлж эхлэхийг Засгийн газар /С.Батболд/-т үүрэг болгосугай:

1/Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр;

2/Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого";

3/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоолд заасан "Сайншанд" аж үйлдвэрийн цогцолбор";

4/Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 47 дугаар тогтоолоор баталсан "Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр барих авто зам, эрчим хүчний барилга, байгууламжийн жагсаалтад орсон төсөл, хөтөлбөр.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Д.Зоригт/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар  
сарын 8-ны өдөр

Дугаар 317

Улаанбаатар  
хот

## Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай

Онцгой албан татварын тухай хуулийн 6.7-д заасныг үндэслэн  
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Импортоор оруулж байгаа автобензин, дизелийн түлшний  
онцгой албан татварын хэмжээг 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс  
эхлэн дор дурдсанаар тогтоосугай:

№	Хилэйн боомтын нэр	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ (төгрөгөөр)		
		Автобензин (шяажилгээний аргаар тодорхойлсон октаны хэмжээ)		Дизелийн түлш
		90 хүртэл	90 болон түүнээс дээш	
1	Цагааннуур, Ярант, Боршоо, Ардсуурь, Тэс, Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхошуу, Бичигт, Хавирга	0.000	0.000	0.000
2	Ханх, Ульханмайхан	0.000	0.000	0.000
3	Сүхбаатар, Замын-Үүд, Эрэнцав, Алтанбулаг	190.000	230.000	20.000

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Газрын тосны зарим  
бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай" Засгийн газрын 2010 оны  
11 дүгээр сарын 10-ны өдрийн 292 дугаар тогтоолыг хүчингүй болсонд  
тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ  
ХҮЧНИЙ САЙД**

**Д.ЗОРИГТ**

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн редакци,

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin\_medecl@parliament.mn

Утас: 262420, 329617

Хэвлэлийн хуудас 4.25

Индекс: 14003

ҮНДЭМЛЭГ

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
хууль

388

Монгол Улсын  
хууль

430


Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол

450

Нотариатын тухай

Монгол Улсын Хөгжлийн  
банкны тухай

Зээлийн баталгааны дээд  
хэмжээг тогтоох тухай



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэл хэргийн хэлтэс  
Утас 329487